



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улиастай сумын Хүүхдийн 4-р цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ЗАА-2024/208/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улиастай сум

2024 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын

тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: [Bat-Undraa@audit.gov.mn](mailto:Bat-Undraa@audit.gov.mn)

Аудитын менежер : Х.Болдбаатар

Утас:99105506

Цахим хаяг: [BoldbaatarKh@audit.gov.mn](mailto:BoldbaatarKh@audit.gov.mn)

Ахлах аудитор: Ц.Оюунсүвд

Утас: 99076038

Цахим хаяг: [oyunsuvdts@audit.gov.mn](mailto:oyunsuvdts@audit.gov.mn)

Гэрээт аудитор : Ц.Алтантуул

Утас:91195554

Цахим хаяг: [tuul9565@gmail.com](mailto:tuul9565@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. Аудитын илрүүлэлт .....	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	16

---

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12  
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2024.02.23 № 469

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

УЛИАСТАЙ СУМЫН ХҮҮХДИЙН  
ДӨРӨВДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Д.ЦЭГМИД-Д

### Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улиастай сумын Хүүхдийн дөрөвдүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас Улиастай сумын Хүүхдийн дөрөвдүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Улиастай сумын Хүүхдийн дөрөвдүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлангийн аудитаар жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгээгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээ данс бүртгэлд тусгасан, бараа материалын тайланд хүнсний материалын зарцуулалтыг буруу тусгасан зэрэг зөрчил илэрсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.6-д эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг зөрчиж, тохиолдсон байх, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Улиастай сумын Хүүхдийн дөрөвдүгээр цэцэрлэг нь нийт 674.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлж зарцуулсанаас 609.8 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаанаас, 60.6 сая төгрөгийг орон нутгийн санхүүжилтээс, 4.0 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтээр бүрдүүлсэн байна.

Audit(D)Дүгнэлт/2024

### **Аудитын гол асуудал**

Улиастай сумын Хүүхдийн дөрөвдүгээр цэцэрлэг нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар зардлыг эдийн засгийн ангиллаар зарцуулаагүй, цэцэрлэгийн хүүхдийн тоо зөрүүтэй тусган харуулсан зэрэг зөрчил илэрсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Хүнсний материалын худалдан авалтыг гэрээ хийгээгүй, шинжилгээний бичиггүй худалдан авсан, нярвын тайланд хоолны технологийн карт хөтлөөгүй зэрэг алдаа байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР Д.БАТ-УНДРАА



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>48,781,378.72</u></b>	<b><u>86,781,254.25</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	47,982.28	32,063,599.81
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	47,982.28	32,063,599.81
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	47,982.28	32,063,599.81
31211	Төрийн сангийн харилцах	47,982.28	32,063,599.81
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	48,733,396.44	54,717,654.44
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	14,882,287.12	14,578,099.12
35110	Тусгай зориулалттай материал	14,147,287.12	13,843,099.12
35130	Эм боох материал	735,000.00	735,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	33,851,109.32	40,139,555.32
35410	Бичиг хэргийн материал	649,900.00	608,000.00
35420	Аж ахуйн материал	24,354,756.32	32,730,956.32
35440	Түлш, шатах тослох материал	600,005.00	1.00
35450	Барилгын засварын материал	2,927,500.00	2,877,000.00
35460	Хүнсний материал	1,725,348.00	329,998.00
35470	Бусад хангамжийн материал	3,593,600.00	3,593,600.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>629,509,317.80</u></b>	<b><u>621,852,785.84</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	629,509,317.80	621,852,785.84
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	618,474,317.80	611,147,785.84
39201	Барилга, байгууламж, орон сууц	673,481,250.00	673,481,250.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(69,104,727.84)	(86,380,909.80)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	53,199,515.26	53,199,515.26
39206	Хуримтлагдсан элэгдэл	(43,748,172.19)	(45,709,304.23)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,319,641.55	52,519,641.55
39208	Хуримтлагдсан элэгдэл	(34,192,798.98)	(36,482,016.94)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,227,323.20	1,227,323.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,227,323.20)	(1,227,323.20)
39217	Ном	519,610.00	519,610.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	11,035,000.00	10,705,000.00
39301	Програм хангамж	1,850,000.00	1,850,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(915,000.00)	(1,245,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	10,100,000.00	10,100,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>678,290,696.52</u></b>	<b><u>708,634,040.09</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>672,539,671.52</u></b>	<b><u>708,634,040.09</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	672,539,671.52	708,634,040.09
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	127,012,448.68	127,012,448.68
51101	Өмч: - төрийн	127,012,448.68	127,012,448.68

512	Хуримтлагдсан үр дүн	520,709,127.84	556,803,496.41
51210	Өмнөх үеийн үр дүн	520,709,127.84	520,709,127.84
51220	Тайлант үеийн үр дүн	-	36,094,368.57
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	24,818,095.00	24,818,095.00
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>678,290,696.52</b>	<b>708,634,040.09</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	-	<b>674,486,100.00</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	-	<b>674,486,100.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	609,874,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	609,874,900.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	4,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	4,000,000.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	-	60,611,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	60,611,200.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	-	<b>652,591,731.43</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>652,591,731.43</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	652,591,731.43
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	422,720,998.61
210101	Үндсэн цалин	-	253,035,396.55
210102	Нэмэгдэл	-	137,098,708.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	126,200.00
210104	Урамшуулал	-	32,145,193.75
210105	Гэрээт ажлын хөлс	-	315,500.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	-	55,768,300.00
210201	Тэтгэврийн даатгал	-	38,241,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	4,499,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	3,476,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	868,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	8,682,600.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	-	62,211,204.00
210301	Гэрэл, цахилгаан	-	5,085,269.66
210302	Түлш, халаалт	-	45,601,204.00
210303	Цэвэр, бохир ус	-	11,524,730.34
2105	<b>Нормативт зардал</b>	-	77,980,450.00

210502	Хоол, хүнс	-	77,980,450.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	1,047,954.86
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,047,954.86
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	32,862,823.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	11,006,292.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	21,856,531.96
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-</b>	<b><u>21,894,368.57</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-</b>	<b><u>21,894,368.57</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>-</b>	<b><u>674,486,100.00</u></b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>-</b>	<b>674,486,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>-</b>	609,874,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	609,874,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>-</b>	4,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	4,000,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>-</b>	60,611,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	60,611,200.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>-</b>	<b><u>642,470,482.47</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>642,470,482.47</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>642,470,482.47</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>-</b>	428,002,123.61
210101	Үндсэн цалин	-	268,139,357.72
210102	Нэмэгдэл	-	134,150,934.14
210104	Урамшуулал	-	25,711,831.75
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>-</b>	56,238,200.00
210201	Тэтгэврийн даатгал	-	38,242,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	4,499,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	3,599,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	900,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	8,998,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>-</b>	61,611,200.00
210301	Гэрэл, цахилгаан	-	5,084,969.66

210302	Түлш, халаалт	-	45,001,200.00
210303	Цэвэр, бохир ус	-	11,525,030.34
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	<b>76,585,100.00</b>
210502	Хоол, хүнс	-	76,585,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	<b>3,000,000.00</b>
210604	Урсгал засвар	-	3,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	<b>1,047,954.86</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,047,954.86
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	<b>15,985,904.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	12,636,604.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	3,349,300.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>=</b>	<b><u>32,015,617.53</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>32,015,617.53</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>47,982.28</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>47,982.28</b>	<b>32,063,599.81</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	127,012,448.68	24,818,095.00	520,709,127.84	672,539,671.52
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	127,012,448.68	24,818,095.00	520,709,127.84	672,539,671.52
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	127,012,448.68	24,818,095.00	520,709,127.84	672,539,671.52
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	36,094,368.57	36,094,368.57
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	127,012,448.68	24,818,095.00	556,803,496.41	708,634,040.09

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>577,859,282.47</b>

21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	577,859,282.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	577,859,282.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	428,002,123.61
210101	Үндсэн цалин	0.00	268,139,357.72
210102	Нэмэгдэл	0.00	134,150,934.14
210104	Урамшуулал	0.00	25,711,831.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	56,238,200.00
210201	Тэтгэврийн даатгал	0.00	38,242,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	4,499,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	3,599,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	900,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	8,998,100.00
2105	Нормативт зардал	-	76,585,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210502	Хоол, хүнс	-	76,585,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,047,954.86
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	15,985,904.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	12,636,604.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	3,349,300.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	609,874,900.00
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	609,874,900.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	-	609,874,900.00
4	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>47,982.28</b>
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>32,063,599.81</b>

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улиастай сумын Хүүхдийн 4-р цэцэрлэг нь Бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 19 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 96.0 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

##### **Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын

зөвлөл нь 2023 оны ажлын төлөвлөгөөндөө 5 ажил хийхээр төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт бүрд удирдамж батлуулж, хяналтаар илэрсэн зөрчлийг арилгаж ажилласан байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улиастай сумын Хүүхдийн 4-р цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улиастай сумын Хүүхдийн 4-р цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 76,349.4 мянган төгрөгөөр буюу 9.2 хувиар буурсан байна.

**Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	48,733.30	54,717.60	(5,984.30)
Үндсэн хөрөнгө	629,509.30	621,852.70	7,656.60
Нийт хөрөнгө	678,290.60	708,634.00	(30,343.40)
Өр төлбөр	5,751.00	-	5,751.00
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	672,539.60	708,634.00	(36,094.40)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	678,290.60	708,634.00	(30,343.40)

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайланд онд

Бараа материал эхний үлдэгдэл 48,733.3 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 90,261.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 84,277,0 мянган төгрөг хасагдаж эцсийн үлдэгдэл 54,717.6 мянган төгрөг болж өмнөх оноос 5,984.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй 14,200.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж жилийн эцэст 7,656.6 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 21,856.5 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 30,343.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 609,874.9 мянган төгрөгөөр нийт зарлагыг 609,874.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 609,874.9 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 609,874.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 577,859.2 мянган төгрөг буюу 94.7 хувьтай байгаа ба мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 32,063.5 мянган төгрөг байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>Улсын төсвөөс санхүүжих</b>					
71601					
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	609,874.5	609,874.5		94.7
<b>НИЙТ</b>		609,874.5	609,874.5		<b>94.7</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 64,611.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж зарцуулсан байна.

#### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2023 онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

#### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

/Мянган төгрөг/

№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Шууд гэрээ байгуулах	Түлш халаалт	14,034.50	14,034.20
2	Шууд гэрээ байгуулах	Гэрэл цахилгаан	2,525.20	2,647.50
3	Шууд гэрээ байгуулах	Цэвэр, бохир ус	1,379.20	1,053.00
4	Шууд гэрээ байгуулах	Харилцаа холбооны зардал	572.90	1,231.50
5	Шууд гэрээ байгуулах	Тээвэр шатахуун	7,995.60	6,918.40
6	Шууд гэрээ байгуулах	Хог хаягдал зайлуулах	715.40	210.30
7	Шууд худалдан авалт	Багаж хэрэгсэл	2,199.50	2,199.50
	ДҮН		29,422.30	28,294.40

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

#### 4. АУДИТЫН ТАЙЛАН

##### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Улиастай сумын Хүүхдийн 4-р цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ари финайнс аудит ХХК-ийн гэрээт аудитор Ц.Алтантуул гүйцэтгэж, хяналтыг Ари финайнс аудит ХХК-ийн захирал Д.Ариунаа анхан шатанд хянаж, Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд, аудитын менежер Х.Болдбаатар нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа дараагийн шатанд хяналтыг хэрэгжүүлсэн.

Улиастай сумын Хүүхдийн 4-р цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ари финайнс аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 06 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

##### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 168,900.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 2,535.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 1,900.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 652,591.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 9,788.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7,341.6 мянган төгрөгөөр тогтоосон

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 29 зүйл заалтаар хяналтыг хэрэгжүүлсэн ба алдаа зөрчил илрээгүй байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Улиастай сумын Хүүхдийн 4-р цэцэрлэгийн төвийн 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийж гүйцэтгээгүй байна.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар 2,415.9 мянган төгрөгийн 1 зөвлөмж, 962.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосныг биелүүлсэн байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар 707,019,930.0 төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд 1,855,690 төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 705,164,240 төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

Аудитын илрүүлэлт нийт 707,019.93 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс өндөр тул Сөрөг дүгнэлт өглөө.

#### **5.1 Зөвлөмж хүргүүлээгүй**

#### **5.2 Албан шаардлага**

676,570,440.28 төгрөгийн хөрөнгийн тооллого хийгээгүй, 8,596,650 төгрөгийн худалдан авалтын анхан шатны баримтын бүрдэлийг бүрэн хангаж ажиллаагүй, 2,291,246,81 төгрөгийн зардлыг эдийн засгийн ангилалаар зарцуулаагүй 17,705,900 төгрөгийн хоолны тайлан гаргаагүй зэрэг зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

#### **5.3 Төлбөрийн акт**

Бараа материалын үлдэгдлийн тулгалтаар 1,855,690 төгрөгийн хоолны материал дутагдсан зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		Тоо		Дүн
Хөрөнгийн тооллого хийгээгүй	1	676,570.44			1	676,570.44	1	676,570.44		
Худалдан авалтын анхан шатны баримтын бүрдэлийг бүрэн хангаж ажиллаагүй	1	8,596.65			1	8,596.65	1	8,596.65		
Зардлыг эдийн засгийн ангилалаар зарцуулаагүй	1	2,291.25			1	2,291.25	1	2,291.25		
Хоолны тайлан гаргаагүй	1	17,705.90			1	17,705.90	1	17,705.90		
Бараа материалын үлдэгдлийн тулгалтаар хоолны материал дутагдсан байна.	1	1,855.69	1	1,855.69						
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>707,019.93</b>	<b>1.00</b>	<b>1,855.69</b>	<b>4.00</b>	<b>705,164.24</b>	<b>4.00</b>	<b>705,164.24</b>	<b>4.00</b>	<b>0.00</b>

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *[Signature]* Д.БАТ-УНДРАА ОГНОО: 2024-02-22

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР *[Signature]* Х.БОЛДБААТАР ОГНОО: 2024-02-22

АХЛАХ АУДИТОР

Ц.ОЮУНСУВД ОГНОО: 2024-02-22

АРИ ФИНАЙНС АУДИТ ХХК-ИЙН

ГЭРЭЭТ АУДИТОР *[Signature]*

Ц.АЛТАНТУУЛ ОГНОО: 2024-02-22